

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/19/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн: чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК ба түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
5.1 Төлбөрийн акт.....	13
5.2 Албан шаардлага.....	13
5.3 Зөвлөмж.....	13
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлчилгээний газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.06 № 01/262
танай _____ -ны № _____ -т

“ШИНЭ-ИДЭР ДУЛААН ЭРДЭНЭТ” ХХК -
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.БААСАНЖАВ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болсон байна.

Аудитын гол асуудал

Шинэ-Идэр сумын “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК-ын ТУЗ нь 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 11 тоот тогтоолоор Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан зорилтот түвшинд заасан зардлын дүнг 20.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Цаашид зорилтот түвшний зардлын хязгаарыг нэмэгдүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК нь 2022 оны зорилтот түвшний үйл ажиллагааны биелэлтийг 100.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2022-01-01	2022-12-31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	26,274,432.85	5,409,025.61
1.1.4	Бусад авлага	19,609,303.43	15,601,026.45
1.1.6	Бараа материал	16,324,035.19	19,403,755.32
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	62,207,771.47	40,413,807.38
1.2.1	Үндсэн хөрөнгө	620,738,606.03	646,754,339.53
1.2.2	Биет бус хөрөнгө	14,395,541.67	14,258,041.67
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	635,134,147.70	661,012,381.20
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	697,341,919.17	701,426,188.58
2.1.1.1	Дансны өглөг	228,175.00	193,978.79
2.1.1.3	Татварын өр	1,806,916.32	4,558,002.07
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,035,091.32	4,751,980.86
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		928,020.32
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		928,020.32
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,035,091.32	5,680,001.18
2.3.1	Өмч: - төрийн	687,676,437.96	687,676,437.96
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- Хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	207,155,817.14	207,155,817.14
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	24,539,500.00	24,539,500.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(224,064,927.25)	(223,625,567.69)
	Өмнөх үеийн үр дүн		(224,064,927.25)
2.3.10	Тайлант үеийн үр дүн		439,359.56
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	695,306,827.85	695,746,187.41
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	697,341,919.17	701,426,188.58

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант он
9	Борлуулалтын орлого(цэвэр)	265,054,754.11	474,004,641.26
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	240,486,032.57	396,486,239.91
3	Нийт ашиг (алдагдал)	24,568,721.54	77,518,401.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	48,821,593.40	76,067,621.50
11	Санхүүгийн зардал	0.00	83,400.00
17	Бусад ашиг (алдагдал)	8,166,188.98	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(25,195,005.26)	1,367,379.86
19	Орлогын татварын зардал	0.00	(928,020.30)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(16,086,682.95)	439,359.56
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(16,086,682.95)	439,359.56
24	Орлогын нийт дүн	(16,086,682.95)	439,359.56

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	687,676,437.96	205,380,817.14	14,132,000.00	(260,237,001.65)	646,952,253.45
Тайлант цэвэр (алдагдал) үеийн ашиг	0.00	0.00	0.00	36,172,074.40	36,172,074.40
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	1,775,000.00	10,407,500.00	0.00	12,182,500.00
2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	687,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(224,064,927.25)	695,306,827.85
Тайлант цэвэр (алдагдал) үеийн ашиг	0.00	0.00	0.00	439,359.56	439,359.56
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	687,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(223,625,567.69)	695,746,187.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	277,199,712.31	526,020,070.21
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	274,597,960.50	526,020,070.21
	Бусад мөнгөн орлого	2,601,751.81	
1.2	Мөнгөн зарлага (-)	275,080,764.27	473,063,477.45
	Ажиллагчдад төлсөн	88,130,831.00	161,453,795.38
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	28,708,556.00	43,798,703.61
	Бараа материал худалдан авахад төлсөн	6,400,100.00	84,282,899.00
	Ашиглалтын зардалд төлсөн	65,896,815.00	73,305,590.33
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	52,718,125.00	64,720,075.00
	Татварын байгууллагад төлсөн	26,029,048.27	38,704,528.63
	Хүүний төлбөрт төлсөн	180,000.00	
	Даатгалын төлбөрт төлсөн	141,840.00	82,875.00
	Бусад мөнгөн зарлага	6,875,449.00	6,715,010.50
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,118,948.04	52,956,592.76
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,529,900.00	66,822,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,529,900.00	66,822,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,529,900.00)	(66,822,000.00)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		7,000,000.00
	Төлсөн ногдол ашиг		7,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(7,000,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,410,951.96)	(20,865,407.24)
5	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	28,685,384.81	26,274,432.85
	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	26,274,432.85	5,409,025.61

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Орлогын ангилал	/төгрөгөөр/			Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Үйлчилгээний орлого	470,737,451.00	470,792,182.17	-54,731.17	100.01
2	Усны орлого	1,236,362.40	2,176,095.45	-939,733.05	176.01
3	Түрээсийн орлого	1,036,362.00	1,036,363.64	-1.64	100.00
4	Нийт орлогын дүн	473,010,175.40	474,004,641.26	-994,465.86	100.21
	Нийт зардал				
1	Цалин	160,670,528.00	158,509,150.00	2,161,378.00	98.65
2	НДШ	24,129,922.00	24,121,569.00	8,353.00	99.97
3	Нүүрс худалдан авах	60,558,000.00	56,957,341.59	3,600,658.41	94.05
4	Нүүрс тээвэрлэлт	61,800,000.00	61,777,872.67	22,127.33	99.96
5	Түлш шатахуун	10,890,909.00	10,837,286.42	53,622.58	99.51
6	Цахилгааны зардал	47,500,000.00	46,399,588.94	1,100,411.06	97.68
7	Хөдөлмөр хамгаалалын зардал	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.00
8	Шуудан холбоо	1,000,000.00	740,000.00	260,000.00	74.00
9	Бичиг хэрэг	2,000,000.00	1,188,258.00	811,742.00	59.41
10	Томилолт	1,350,000.00	1,321,000.00	29,000.00	97.85
11	Засвар үйлчилгээ	11,000,000.00	10,978,300.00	21,700.00	99.80
12	Шугам засварын зардал	13,850,000.00	12,918,263.00	931,737.00	93.27
13	ТУЗ-ийн зардал	7,276,500.00	7,276,500.00	0.00	100.00
14	ТХ Татвар даатгалын зардал	300,000.00	293,695.00	6,305.00	97.90
15	Газар ус ашигласны төлбөр	600,000.00	593,037.00	6,963.00	98.84
16	ЭХЗЗ-ийн үйлчилгээний зардал	1,400,000.00	1,399,597.50	402.50	99.97
17	ҮХХ-ийн татварын зардал	200,000.00	200,000.00	0.00	100.00
18	Кадастрын зураг	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
19	Нохой устгал	720,000.00	720,000.00	0.00	100.00
20	Сургалтын зардал	1,100,000.00	1,090,000.00	10,000.00	99.09
21	Тэтгэмж урамшуулал, нийгмийн асуудал	10,100,000.00	8,490,636.00	1,609,364.00	84.07
22	Элэгдэлийн зардал	40,000,000.00	41,041,766.53	-1,041,766.53	102.60
23	Ноогдол ашиг	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.00
24	ОАТЗардал	136,737.98	136,737.98	0.00	100.00
25	Банкны шимтгэл	83,400.00	83,400.00	0.00	100.00
26	Нийт зардлын дүн	481,165,996.98	471,573,999.63	9,591,997.35	83.98

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**3.1 “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК ба түүний үйл ажиллагаа**

Тус компани нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлнэ.

Компани нь нийт 20 ажилтантай ба Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан үйлдвэрлэх, түгээх, борлуулах
- Ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Компани нь 2013 оноос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК болон өөрчлөгдсөн байна.

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

Компанийн гүйцэтгэх захирлыг Хөвсгөл аймгийн Тариалан сумын “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК -ийн ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны 02 дугаар тогтоолоор томилсон байна.

Байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгжийг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/01 захирлын тушаалаар томилсон байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн ИТХ болсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр захирлын тушаалаар баталсан бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 1-ний дотор шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Компани нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагдах аргаар бүртгэж тайлагнадаг.

Санхүүгийн бүртгэлийн программаар Leader программыг ашигладаг ба үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй уялдаагүй мэдээлэл солилцоход хүндрэлтэй, систем дотроо цалин хөлс, урьд оны үлдэгдэл зэрэг мэдээллийг дутуу татаж санхүүгийн тайланг алдаатай илэрхийлж, дахин дахин тооцоолохтой холбогдож нягтлан бодогчид болон бидний ажилд хүндрэл учруулж байна.

Тухайлбал: Өртөг, зардлын хуваарилалтыг бүрэн хийх боломжгүй, гар ажиллагаа ихтэй байна.

“Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК -ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.1 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар өсөж 701.4 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26.3	5.4	(20.9)
Авлага	19.6	15.6	(4.0)
Бараа материал	16.3	19.4	3.1
Үндсэн хөрөнгө	620.7	646.7	26.0
Биет бус хөрөнгө	14.4	14.3	(0.1)
Нийт хөрөнгө	697.3	701.4	4.1
Өр төлбөр	2.0	5.7	3.7
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	695.3	695.7	0.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	697.3	701.4	4.1

Банканд бэлэн байгаа мөнгө 5.4 сая байна. Өр төлбөр 3.7 сая төгрөгөөр өсөж 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дансны авлагын үлдэгдэл 4.0 сая төгрөгөөр буурч 15.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19.4 сая төгрөг болж өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр өссөн нь нүүрсний үнэ ханш нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 26.0 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 119 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралаар “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталжээ. Тайлант оны нийт орлогыг 465.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 461.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 10 дугаар тогтоолоор бизнес төлөвлөгөөний нийт орлогыг 499.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 472.0 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 32.8 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 470.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 481.2 сая төгрөгөөр тодотгол хийсэн байна.

Гүйцэтгэлээр 474.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 472.6 сая төгрөгийн зардал гаргаж ажилласан байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

дд	Үзүүлэлт	2022			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
	Үйлчилгээний орлого	470.7	470.8	0.1	100.0
	Усны орлого	1.2	2.2	1.0	176.0
	Түрээсийн орлого	1.0	1.0	-	100.0

2	НИЙТ ОРЛОГО	473.0	474.0	1.0	100.2
3	НИЙТ ЗАРДАЛ	481.2	472.6	(9.6)	98.0
4	Татварын өмнөх ашиг	40.2	1.4	(38.8)	
5	Цэвэр ашиг /алдагдал/	36.2	1.4	(34.8)	
8	Нийт ажиллагсдын тоо	20	20	-	100.0
9	Нийт цалингийн сан	160.7	158.5	(2.2)	98.6
15	НИЙТ АВЛАГА	19.6	15.6	(4.0)	79.6
16	НИЙТ ӨГЛӨГ	2.0	4.9	2.9	245.0
	Үүнээс: Богино хугацаат	2.0	4.9	2.9	245.0

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлын данстай холбоотой, гэрээ хэлцлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

“Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК -ийн 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томиллолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн бүртгэж оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 108.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 10.4 сая төгрөгийн залруулга хийж, 97.7 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	97.7	2	97.7	100
Нийт дүн	2	97.7	2	97.7	100

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Шинэ-Идэр сумын “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК-ын ТУЗ нь 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11 тоот тогтоолоор Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан зорилтот түвшинд заасан зардлын дүнг 20.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан "Орон нутгийн өмчит компаниудын 2022 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин батлах тухай" тогтоолын 7 дугаар хавсралттай нийцэхгүй байна.
- Аймгийн ИТХ-д зорилтот түвшнийг нэмэгдүүлэх хүсэлт тавьсан боловч ТУЗ-аар шийдвэрлүүлэх чиглэл өгсөн. Цаашид зорилтот түвшний зардлын дээд хязгаарыг нэмэгдүүлэхдээ аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулж байгаа эсэхийг дараагийн аудитын анхаарах асуудал гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, аудитын явцад 0.1 сая төгрөгийн алдааг залруулж 4 зөвлөмж өгсөн. Үүнд:

Шинэ-Идэр сумын “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК нь тайлант онд Халуун ус, үсчний суудал түрээсэлж 1.0 сая төгрөгийн түрээсийн орлого олсон боловч хөрөнгө түрээслүүлсэн 0.1 сая төгрөгийн татвараа бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь 20.2 “Албан татвар

төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна" 20.2.1 энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.7, 18.7-д заасан орлогод 10 хувиар" заалтуудтай нийцэхгүй байгааг татварын өглөг, зардлыг санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайланд тусгаж залрууллаа.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 50.2 сая төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 гэсэн заалттай нийцээгүй ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэхгүйгээр, бөөн дүнгээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хэмжилт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэх.

3. Шилэн дансны хөтлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.0 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг шилэн дансанд огт шивээгүй байна. Зөрүүтэй гүйлгээ 15.0 сая төгрөгийн 2 гүйлгээ шивсэн нь, Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.9, 3.2.10 дахь заалт, "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

4. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2018 онд болосруулан мөрдөж байгаа нягтлан бодох бодлогын баримт бичиг нь одоогийн мөрдөгдөж буй хууль, журам, тушаалд нь нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгө түрээслүүлсэн 0.1 сая төгрөгийн татвараа бүртгэж тайлагнаагүй	1	0.1	1	0.1			1	0.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн. /И баримтгүй/	1	50.2	-	-	-	-	1	50.2				
Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэхгүйгээр, бөөн дүнгээр бүртгэсэн	1	0.4	-	-	-	-	1	0.4				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлага хангаагүй	1	0					1	0				
Нийт дүн	3	50.6	0	0	0	0	3	50.6	0	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлээгүй	1	20.0					1	20.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

